

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ
ОРШИХ “ШАРАНГАТАЙ” НЭРТЭЙ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ”
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: “ТЕРРА ВИСТА” ХХК

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-022056

АГУУЛГА

ОРШИЛ	1
НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1 Төслийн товч тодорхойлолт	2
1.2 Төслийн талбайн байршил	2
1.3 Уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа	3
1.4 Уурхайн дэд бүтэц	3
1.5 Усан хангамж	4
1.6 Цахилгаан хангамж.....	5
1.7 Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө.....	6
1.8 Хог хаягдал	6
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ	7
2.1. Төсөл хэрэгжих талбай орчмын физик, газар зүй, ландшафт	7
2.2. Цаг уур, уур амьсгал	7
2.3. Агаарын чанар	7
2.4. Геоморфологи.....	9
2.5. Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал.....	10
2.6. Ургамлын нөмрөгийн төлөв байдал.....	11
2.7. Амьтны аймаг.....	12
2.8. Гадаргын ус.....	13
ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ	14
3.1 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл.....	14
3.3 Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ.....	18
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	21
4.2. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө	24
4.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	24
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	24
4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	24
4.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	25
4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	27
4.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	27
4.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	29
4.10. Нөлөөллийн бүсийн иргэдэд тайлагнах ажлын төлөвлөгөө	30

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Төслийн байршил	2
Зураг 2.	MP-68C-60 маркийн дизель генератор	5

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Ил уурхайн ажлын горим.....	3
Хүснэгт 2.	Уурхайн барилга, байгууламж	4
Хүснэгт 3.	Агаарын дундаж температур	8
Хүснэгт 4.	Хөрсний хэв шинж	10
Хүснэгт 5.	Ургамлын төрөл зүйл	11
Хүснэгт 6.	Амьтны аймгийн төрөл зүйл.....	12
Хүснэгт 7.	Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	14
Хүснэгт 8.	Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах	16
Хүснэгт 9.	Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл	17
Хүснэгт 10.	Гол сөрөг нөлөөлөл	18
Хүснэгт 11.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	18
Хүснэгт 12.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	21
Хүснэгт 13.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	24
Хүснэгт 14.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	25
Хүснэгт 15.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	25
Хүснэгт 16.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	27
Хүснэгт 17.	Орчны хяналт шинжилгээний хөлөтбөр	28
Хүснэгт 18.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	29
Хүснэгт 19.	Нөлөөллийн бүсийн иргэдэд тайлагнах ажлын төлөвлөгөөний зардал	30
Хүснэгт 20.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн.....	31

ОРШИЛ

“Терра виста” ХХК-ийн “Шарангатай нэртэй хайлуур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах” төслийн /цаашид “төсөл” гэх/ ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг дэвсгэрт оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

“Терра Виста” ХХК-ийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд болон төслийн үйл ажиллагаа, төсөл хэрэгжиж буй талбайн төлөв байдал болон төслийн талбай орчимд хийгдсэн өмнөх шинжилгээний дүнг ашиглаж, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайдын 2019-10-29-ны А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөгөөр Төслийн үйл ажиллагаатай холбогдон үүсэж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь зөвхөн төслийн ашиглалтын үйл ажиллагаанд үндэслэн хийгдсэн бөгөөд холбогдох бусад бүхий л ажиллагааг байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй нягт уялдуулан ажиллах нь зайлшгүй шаардлагатай юм.


НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн товч тодорхойлолт

Төслийн нэр	“Шарангатай” нэртэй хайлуур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах” төсөл
Төсөл хэрэгжүүлэгч	“ТЕРРА ВИСТА” ХХК.
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 22-р хороо, Төгөл хаус, 12-1 тоот.
Улсын бүртгэлийн гэрчилгээ	9011554003
Регистрийн дугаар	5968216
Төсөл хэрэгжүүлэх талбайн байршил	MV-022056 тусгай зөвшөөрөл бүхий “Шарангатай” хайлуур жоншны орд нь засаг захиргааны хувьд Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт харьяалагдана.

1.2 Төслийн талбайн байршил

MV-022056 дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Шарангатай” хайлуур жоншны орд нь засаг захиргааны нэгжийн хувьд Өлзийт сумын нутаг дэвсгэрт байрлана. Төслийн талбай нь Улаанбаатар хотоос урагш чиглэлд хатуу хучилттай авто замаар ойролцоогоор 356 км зайд орших бөгөөд Хулд сумын төвөөс зүүн тийш 36 км-т байрладаг. Тус орд нь говь-хээрийн бүсийн шилжилтийн бүсэд хамаарах бөгөөд газрын гадаргын хувьд нам толгод, ухаа гүвээ бүхий тогтоцтой, уул уурхайн олборлолт явуулахад тохиромжтой нөхцөлтэй газар нутагт оршдог.



Зураг 1. Төслийн байршил

1.3 Уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа

Ашиглалтын систем: Ордын уул-техникийн нөхцөл, хүдрийн биетийн геологийн тогтцыг харгалзан ил аргаар, экскаватор-автосамосвалын хослол бүхий тээвэртэй, гадаад болон гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглана.

Доголын өндөр: Хүдрийн хаягдал бохирдлыг бага байлгах, хүдрийн биетийн цул тогтцоос хамааруулан уурхайн ажлын доголын өндрийг $H_d=5\text{м}$ байхаар тооцов. Доголын өндөр бага байснаар хүдэр хөрсний чулуулгийн зааг орчимд үүсэх хаягдал болон бохирдлын хэмжээ багасах нөхцөл бүрдэнэ.

Ажлын бус доголын өндөр: Уурхайн ажлын доголыг цаашид ашиглахгүй, ил уурхайн хүрээ хязгаарт хүрсэн үед ажлын доголуудыг нэгтгэн ажлын бус догол үүсгэнэ. Ажлын бус доголын өндөр 10 м байна.

Ажлын доголын хажуугийн налуугийн өнцөг: Ажлын доголын хажуугийн налуугийн өнцгийг чулуулгийн шинж чанарын нөхцөлөөр тодорхойлоход хөрс, хүдрийн доголд $\alpha_d=600$ байна. Шинээр ашиглалтын түвшин нээхэд огтлох траншейгаар нээнэ. Траншей нээх, ажиллах техникийн аюулгүй зайн нөхцөлөөр ажлын талбай тодорхойлогдоно. Ажлын хамгийн бага өргөн 25 м-ээс багагүй байна.

Уулын ажлын горим: Уулын ажил нь жилд 8 сар явагдана. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 1 ээлжээр 10 цагаар явагдана. Туслах ажлууд болох цахилгаан хангамж, усан хангамж, гэрэлтүүлэг зэрэг үйлдвэрлэлийн дотоод ажлын зохион байгуулалтаар хийнэ.

Хүснэгт 1. Ил уурхайн ажлын горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хоног
1	Календарь хоног	хоног	180
2	Жилд ажиллах сар	сар	6
3	Ээлжийн үргэлжлэх хугацаа	Цаг	10
4	Ээлжийн тоо	Ээлж	1
5	Баяр ёслолын хоног	хоног	10
6	Цаг агаарын саатал	хоног	8
7	Бэлтгэл ажлын хоног	хоног	2
8	Жилд ажиллах хоног	хоног	160

1.4 Уурхайн дэд бүтэц

Төслийн хүрээнд уурхайн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулахад шаардлагатай үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай барилга байгууламжуудыг уурхайн талбайд төлөвлөсөн. Үүнд захиргаа, удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх захиргааны байр, ажиллагсдын амрах болон байрлах ажилчдын байр, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай хоолны газар, техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх агуулах-засварын байр зэрэг үндсэн барилга байгууламжууд багтана.

Дээрх барилга байгууламжуудыг уурхайн үндсэн олборлолтын бүсээс аюулгүй ажиллагааны шаардлага хангасан зайд, уурхайн зүүн хэсэгт төвлөрүүлэн байршуулахаар төлөвлөсөн байна. Энэхүү байршлын сонголт нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон ажилчдын ахуйн бүсийг оновчтой зохион байгуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл

ахуйн нөхцөлийг хангах, мөн техник тоног төхөөрөмжийн хөдөлгөөн болон дотоод тээврийн урсгалыг зохицуулах давуу талтай юм.

Уурхайн дэд бүтцийн байгууламжууд нь олборлолтын үйл ажиллагааг тасралтгүй дэмжихээс гадна ажиллагсдын ажиллах, амрах орчныг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хадгалалт, засвар үйлчилгээний хэрэгцээг хангах зориулалттай байна. Барилга байгууламжуудыг холбогдох норм, дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн барьж байгуулах бөгөөд байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ашиглана.

Хүснэгт 2. Уурхайн барилга, байгууламж

№	Нэр	Хэмжээ	Хийц бүрдэл	Тоо, ширхэг
1	Сэлбэг, материалын агуулах	30м ²	Контейнер	2
2	Харуул хамгаалалтын байр	5м ²	Сэндвич	2
3	Засварын цех	200м ²	Сэндвич	1
4	Оффис	80м ²	Сэндвич	1
5	Амрах байр	200м ²	Сэндвич	1
6	Гал тогоо	100м ²	Сэндвич	1
7	Душ	20м ²	Контейнер	1
8	Түлшний агуулах	60м ²	ёмкость	1
9	Тэсрэх материалын агуулах	5 тн	Контейнер	1
Нийт		11		

1.5 Усан хангамж

MV-022056 тусгай зөвшөөрлийн талбай нь геологи-гидрогеологийн хувьд харьцангуй сайн судлагдсан, ордыг ашиглах үед гадаргын болоод газрын доорх уснаас үүсэх уул-техникийн хүндрэл үндсэндээ байхгүй. Ордыг ил аргаар ашиглах үед технологийн усны хэрэгцээ гарахгүй бөгөөд уурхайн зам услахад л багахан хэмжээний ус шаардлагатай.

Хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглахад уурхайн мөргөцөг нь газрын гадаргуугаас доош 50 м-т байхад уурхайд газрын доорх ус маш бага хэмжээтэйгээр орж ирэх ба энэ нь гол төлөв агаарын хур тунадасны чөлөөт нэвчилтээс үүссэн ан цавын, ан цавдавхаргын ус байна.

Харин унд ахуйн зориулалттай усыг өрөмдмөл худгийн усаар хангах боломжтой ба энэхүү бүс нутгийн газрын доорх ус нь ундны усны улсын стандартад тохирдоггүй тул усыг шүүж, зөөлрүүлж хэрэглэнэ. Усзүйн хувьд Төв азийн гадагш урсацгүй ай савд Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газарт хамаарна.

Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрыг дотор нь дэд сав газруудад ангилан авч үздэг бөгөөд MV-022056 хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь Өлзийтийн газрын доорх усны дэд сав газарт хамаарна.

Төсөл хэрэгжүүлэгч “Терра виста” ХХК нь унд ахуйн, зам талбайн усалгаа, нөхөн сэргээлтийн усны хэрэглээг гүний худгаас хангахаар төлөвлөсөн байна.

Ордыг ашиглах үед усны дараах үндсэн хэрэглэгч байна. Үүнд:

- Унд ахуйн ус
- Зам талбайн усалгаа
- Биологийн нөхөн сэргээлт

1.6 Цахилгаан хангамж

Уурхайн олборлолт, хүдэр боловсруулах болон ажиллагсдын ахуйн хэрэгцээний цахилгаан эрчим хүчний хэрэглээг бие даасан эх үүсвэрээр хангахаар төлөвлөсөн. Үйлдвэрлэлийн болон дэд бүтцийн байгууламжуудын нийт цахилгаан хэрэглээг 50 кВт болон 160 кВт-ын хүчин чадалтай дизель цахилгаан үүсгүүрүүдээр хангах бөгөөд эдгээр нь уурхайн үйл ажиллагааг тасралтгүй явуулах найдвартай эх үүсвэр болох юм.

Уурхайн цахилгаан хэрэглэгчид нь үндсэндээ хүдэр бутлан ялгах хэсэг, ил уурхайн талбайн гэрэлтүүлгийн систем болон ажиллагсдын хотхон, захиргаа, ахуйн зориулалттай барилга байгууламжуудаас бүрдэнэ. Хүдэр бутлах, ангилан ялгах хэсэг нь цахилгаан эрчим хүчний үндсэн хэрэглэгч болох бөгөөд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор тогтвортой цахилгаан хангамж шаарддаг. Мөн уурхайн олборлолтын ажлыг харанхуй үед болон үзэгдэх орчин хязгаарлагдсан нөхцөлд аюулгүй явуулах зорилгоор ил уурхайн ажлын талбай, дотоод зам, үйлдвэрлэлийн бүсүүдийг гэрэлтүүлэх гэрэлтүүлгийн системийг ажиллуулна.

Ажиллагсдын хотхон болон захиргаа, үйлчилгээний барилга байгууламжуудын цахилгаан хэрэглээнд дотоод гэрэлтүүлэг, халаалт, холбоо мэдээллийн хэрэгсэл, ахуйн цахилгаан тоног төхөөрөмжүүд багтах бөгөөд эдгээрийг дизель үүсгүүрээс түгээх дотоод цахилгаан шугам сүлжээгээр хангана. Цахилгаан хангамжийн системийг уурхайн үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдал болон галын аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн төлөвлөж, ашиглалтын явцад тогтмол хяналт, засвар үйлчилгээг хийж ажиллана.



Зураг 2. MP-68C-60 маркийн дизель генератор

1.7 Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөг захиалагч компанийн техникийн даалгаврын дагуу жилд 40.0 мян.тн -ын хүчин чадалтайгаар ажиллахаар төлөвлөлөө.

1.8 Хог хаягдал

Ахуйн хог хаягдал: Төслийн үйл ажиллагааны явцад ажилчдын байр, хоолны газар, захиргааны байр болон ахуйн зориулалттай бусад байгууламжаас ахуйн хатуу хог хаягдал үүснэ. Үүнд хүнсний үлдэгдэл, цаас, картон, хуванцар сав баглаа боодол, шилэн болон лаазан сав, нэг удаагийн хэрэглээний бүтээгдэхүүн зэрэг хог хаягдал багтана. Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, зориулалтын хогийн саванд цуглуулан түр хадгалсны дараа орон нутгийн эрх бүхий байгууллага эсвэл хог хаягдал тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр тогтмол хугацаанд ачуулж, төвлөрсөн хогийн цэгт хүргүүлэн зайлуулна.

Үйлдвэрлэлийн хог хаягдал: Уурхайн олборлолт, хүдэр бутлах, ялгах, техник тоног төхөөрөмжийн ашиглалт болон засвар үйлчилгээний үйл ажиллагаанаас үйлдвэрлэлийн хог хаягдал үүснэ. Үүнд ашиглалтаас гарсан сэлбэг хэрэгсэл, төмөр хийц, металл хаягдал, кабель утас, модон болон хуванцар сав баглаа боодол, элэгдсэн дугуй зэрэг хог хаягдал хамаарна. Үйлдвэрлэлийн хог хаягдлыг төрөл тус бүрээр нь ангилан цуглуулж, уурхайн талбай дахь зориулалтын агуулах болон овоорох цэгт түр хадгална. Дахин ашиглах болон дахин боловсруулах боломжтой хаягдлыг холбогдох байгууллагад нийлүүлж, үлдсэн хаягдлыг эрх бүхий байгууллагаар зайлуулна.

Аюултай хог хаягдал: Техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ болон шатах тослох материалын хэрэглээнээс аюултай хог хаягдал үүснэ. Үүнд ашигласан тос, тосны шүүр, аккумулятор, батарей, шатах тослох материалын сав, тос шингэсэн алчуур болон бусад шингээгч материалууд багтана. Аюултай хог хаягдлыг хөрс, усанд нэвчихээс хамгаалсан зориулалтын сав, талбайд түр хадгалж, бусад төрлийн хог хаягдлаас тусгаарлан цуглуулна. Улмаар аюултай хог хаягдал боловсруулах, устгах тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад гэрээний үндсэн дээр хүлээлгэн өгч, холбогдох хууль тогтоомжийн дагуу зайлуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Төсөл хэрэгжих талбай орчмын физик, газар зүй, ландшафт

Дундговь аймаг нь Монгол орны физик-газарзүйн мужлалаар Говийн их мужийн Алтайн ар говийн мужийн Нууруудын хөндий тойрог, Хангайн өмнөд бэгэлцэгийн тойрог, Дорнод говийн мужийн Умарт талын гүвээт талын тойрог, Монголын Дорнод талын их мужийн Халхын Дундад ба Дарьгангын талархаг мужийн Ухаа Гүвээт Халхын дундад тал тойрогт багтаж байна. Дундговь аймгийн газар нутгийн хотгор гүдгэрийг ерөнхий төрх байдал, гарал үүслийн үүднээс авч үзэхэд цав толгод болон ухаа гүвээт тал гэсэн хэв шинжид багтана. Дундговь аймгийн өндөржилт нь далайн түвшинээс дээш 1100-1350 метрт өргөгдсөн, нутгийн хамгийн өндөр цэг нь 1926 м өндөрт орших Дэлгэрхангай уул бөгөөд Их, Бага газрын чулуу зэрэг уулс бий.

2.2. Цаг уур, уур амьсгал

Дундговь аймгийн нутаг дэвсгэр нь уур амьсгалын хувьд хуурай, сэрүүн, уулын хээрийн муж /Эрдэнэдалайн хойд хэсэг, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэнгийн хойд хэсэг/, нэн хуурай дулаавтар, цөлөрхөг хээрийн муж /Дэлгэрхангай, Хулд, Луус, Гурвансайхан, Өндөршил сумын хойд хэсэг, Сайхан-Овоо, Сайнцагаан, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Баянжаргалан сумдын нутаг/, нэн хуурай дулаан, цөлөрхөг хээрийн муж /Дэлгэрхангай, Хулд, Гурвансайхан сумдын урд хэсэг, Өлзийт сумын нутаг/ гэж 3 хуваадаг. Агаарын температурын дундаж хэмжээ өвлийн сард – 16-19 градус, зуны сард +17-21 градус, жилд орох хур тундасны хэмжээ 95-150 мм унадаг.

2.3. Агаарын чанар

Дундговь аймаг нь уур амьсгалын мужлалаар нутгийн хойд хэсэг хуурай сэрүүн, дулаавтар зунтай, хагас чийглэг мужид, нутгийн урд хэсэг халуувтар зунтай, хуурайвтар мужид, нутгийн дунд хэсэг дулаан зунтай чийгээр дутмаг мужид багтаж байна. Үүнд:

- Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр сумын зүүн хэсэг, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумын баруун хэсэг дулаавтар зунтай хагас чийглэг уур амьсгалын мужид
- Эрдэнэдалай, Дэлгэрхангай сумын зүүн хэсэг, Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр сумын баруун хэсэг, Өлзийт, Өндөршил сумын хойд хэсэг, Адаацаг, Луус, Сайнцагаан, Гурвансайхан, Говь-Угтаал, Баянжаргалан сумд халуувтар зунтай, хуурайвтар мужид
- Өлзийт, Өндөршил сумын урд хэсэг дулаан зунтай чийгээр дутмаг мужид тус тус багтаж байна (Цэгмид, 1969).

Уур амьсгалын мэдээг Дундговь аймгийн ус цаг уур орчны шинжилгээний төвөөс авсан бөгөөд аймгийн хэмжээнд 6 цаг уурын өртөөтэй байна. Мандалговь өртөө, Эрдэнэдалай өртөө, Сайхан-Овоо өртөө, Гурвансайхан өртөө, Цагаандэлгэр өртөө, Говь-Угтаал өртөө гэсэн 6 цаг уурын өртөөтэй байна.

Цаг агаар, уур амьсгал

Энэхүү уур амьсгалын судалгаанд Дундговь аймгийн Мандалговь сумын цаг уурын станцын ажиглалтын мэдээ цаг уурын автомат станцын мэдээнүүдийг ашиглав.

Уур амьсгалын нөхцөл, улирлын шинж

Аймгийн нутаг дэвсгэрийг уур амьсгалын хувьд хуурай, сэрүүн, уулын хээрийн муж /Эрдэнэдалайн хойд хэсэг, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэнгийн хойд хэсэг/, нэн хуурай дулаавтар, цөлөрхөг хээрийн муж /Дэлгэрхангай, Хулд, Луус, Гурвансайхан, Өндөршил сумын хойд хэсэг, Сайхан-Овоо, Сайнцагаан, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Баянжаргалан сумдын нутаг/, нэн хуурай дулаан, цөлөрхөг хээрийн муж /Дэлгэрхангай, Хулд, Гурвансайхан сумдын урд хэсэг, Өлзийт сумын нутаг/ гэж 3 хуваадаг. Агаарын температурын дундаж хэмжээ өвлийн сард – 16-19 градус, зуны сард +17-21 градус, жилд орох хур тундасны хэмжээ 95-150 мм унадаг.

Агаарын температур

Дэлхийн бөмбөрцгийн сэрүүн бүсэнд багтсан Монгол орон далай тэнгисээс алслагдсан, тал бүрээсээ өндөр уулаар хүрээлэгдэж далайн түвшинээс дээш их өндөрт өргөгдсөн зэргээс шалтгаалан манай оронд агаарын температур ихээхэн ялгавартай, эрс тэс байдалтай юм. Энэ нь өвлийн улирал урт, хүйтэн, зун дулаан, хавар намрын улирал богинохон халуун хүйтэн нь эрс солигдож байдаг. Температурын горимын ийм онцлог нь агаарын температурын жил, сар, хоногийн явц, тэдгээрийн газарзүйн тархалтын байдалд зохих илрэлээ олно.

Монгол орны нутаг бүрийн агаарын температурын хуваарилалтыг авч үзвэл хоногийн температурын хамгийн их, бага хэмжээ хоногт тус бүр нэг удаа тохиолддог буюу ердийн хуваарилалттай юм (Цэгмид, 1969).

Дараах хүснэгтэд Дундговь аймгийн Мандалговь агаарын чанарын харуулын станцын агаарын сарын дундаж температурын утгуудыг 2020–2026 оны байдлаар харууллаа. Агаарын дундаж температур нь тухайн бүс нутгийн дулааны нөхцөл, улирлын температурын өөрчлөлтийг тодорхойлох үндсэн үзүүлэлт бөгөөд уур амьсгалын төлөв байдлыг үнэлэхэд чухал ач холбогдолтой юм.

Хүснэгт 3. Агаарын дундаж температур

Хугацаа	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2020 он	-15.1	-10	-2.9	7.2	12.6	19.2	21.3	18	13	0.8	-6.7	-19.5
2021 он	-17.3	-7.9	-0.7	5.3	10.5	17.6	21.6	17.7	12.9	2.8	-5.6	-11.9
2022 он	-14	-13.3	-3.5	5.3	13	18.8	19.7	17.7	14.5	1.2	-6.8	-16.8
2023 он	-15.9	-9.2	-1.6	2.5	11	19.9	19.6	19.4	13.6	6.4	-8.3	-16.6
2024 он	-17	-16.8	-3.1	6.6	15.2	19.1	21.9	19.3	12	3.6	-3.6	-14.6
2025 он	-14	-12.7	-2	6.9	12.3	19.9	22.8	19.6	13.2	-0.8	-6.9	-14.9
2026 он	-2	-11.6										

Агаарын дундаж температурын утгуудаас харахад судалгааны бүс нутагт улирлын ялгаа тод илэрч байна. Өвлийн улиралд температурын утга –10°C-аас –17°C орчимд хэлбэлзэж, жилийн хамгийн хүйтэн үе I болон II саруудад ажиглагдаж байна. Харин хаврын улиралд температур аажмаар нэмэгдэж, IV сараас эхлэн эерэг утгад шилжинэ. Зуны улиралд температур хамгийн өндөр утгад хүрч, VII сард ихэвчлэн 19–22°C орчимд хэлбэлзэж байгаа нь дулааны улирлын оргил үеийг илэрхийлж байна. Намрын улиралд температур аажмаар буурч, X сараас эхлэн хүйтрэл эрчимжиж байна

Хөрсний температур

Дундговь аймгийн хөрсний гадаргын температурын 2016 оны байдлаар УАД 4.7 градус дулаан, хамгийн их нь 1999 онд 30,8 градус /Гурвансайхан суманд 7 сард/ хүрч халсан, хамгийн бага нь 1985 онд - 30.0 градус /Сайхан-Овоо суманд 1 сард/ хүрч хүйтэрч байсан.

Хөлдөлтийн гүн жил бүр харилцан адилгүй байдаг ба дунджаар 260 см хүрч хөлддөг. УАД-аар 11 дүгээр сарын I-10 хоногт хөрс хөлдөж эхлэдэг бөгөөд 2 дугаар сарын I-10 хоногт бүрэн хөлдөж дуусдаг. Хавар 3 дугаар сарын III-10 хоногоос хөрсний өнгөн үе гэсэж, 4 дүгээр сарын II-10 хоногоос 5 дугаар сарын II-10 хоногийн хооронд хөрс бүрэн гэсэж дуусдаг.

Салхины горим

Их даралттай газраас бага даралттай газар руу чиглэж буй агаарын урсгалыг салхи гэнэ. Агаарын даралтын зөрүү нь салхи үүсгэх шалтгаан болдог. Монгол орны салхины горим өвлийн ид дунд 1-р сард ихэвчлэн баруун хойд, хойд, зүүн хойд зүгийн салхи зонхилно. Зуны улиралд баруун хойд болон баруун хойноос зүүн хойд зүг хүртэлх зовхисын салхи зонхилно. Тэхдээ баруунаас хойд зүг хүртэлх зовхисын салхины давтагдал 44-46 хувь, баруун хойноос зүүн хойд зүг хүртэлх зовхисынх 37-53 хувь, хойноос зүүн зүг хүртэлх зовхисын 14-61 хувь байдгаас үзвэл зуны улиралд салхины зүг чиг өвлийнхийг бодоход төдийлөн тогтвортой биш юм. Дулаан, хүйтэн улирлын салхины чиглэл нь монгол оронд жилдээ бараг нийт нутагт баруун хойноос зүүн хойд зүг хүртэлх зовхисын салхи голлодог ч гэсэн ихэнх нутагт баруун хойд зүгийн салхи дийлэнх болж давтагдал нь 40-70 хувь хүрдэг.

2.4. Геоморфологи

Дундговь аймаг нь геоморфологийн ангиллаар Дорнод Монголын талын мужид хамаарагдана /Мурзаев (1952), Селиванов (1972), Сырнев (1982).

Төслийн талбайд гадаргуугийн элэгдлийн, элэгдэл-тектоникийн, галт уулын гаралтай, хуримтлалын гэсэн гарал үүслийн төрлүүдийг ялгаж байна. Гадаргуугийн гарал үүслийн төрөл тус бүр нь өөртөө тодорхой дүрс хэлбэрийн төрлүүдийг багтааж байдаг.

Элэгдлийн гадаргуу:

Элэгдлийн гадарга нь судалгааны талбайд доор дурдсан дүрс хэлбэрүүдийг өгүүлж байна. Үүнд :

1. Тэгширлийн гадаргуугийн үлдмэл талбайнууд
2. Суурь чулуулагт үүссэн элэгдлийн довжоот тал
3. Дунд ба шинэ төрмөлийн тунамал хурдаст үүссэн давхаргат тал

Тэгширлийн гадаргуугийн талбайнууд нь эрэл-зураглалын талбайн ихээхэн хэсэгт тархсан бөгөөд эдгээр нь нутгийн геологийн түүхэн хөгжлийн явцад дотоод (эндоген) гадаад (экзоген) хүчний нөлөөгөөр хэлбэр дүрсээ өөрчилж орчин үеийн янз бүрийн дүрс хэлбэрүүдийг үүсгэж байна.

Үндсэн чулуулагт үүссэн довжоот тал, дунд, шинэ төрмөл тунамал хурдаст үүссэн давхаргат талууд нь нутгийн платформын хөгжлийн үед үүссэн тэгш талын (пенеплен) хэсгүүд бөгөөд энэ нь гагцхүү оршин тогтнох хугацаанд дээрх хүчин зүйлүүдийн нөлөөгөөр анхны дүрс хэлбэрээ өөрчлөн орчин үеийн гадаргын хэлбэрүүдийг үүсгэжээ. Платформ хөгжлийн үед үүссэн тэгш талын зарим хэсэг нь хэлбэр дүрсээ өөрчлөлгүйгээр орчин үеийн гадаргуу хадгалагдан үлдсэн байна. Эдгээрийг бид хадгалагдан үлдсэн тэгшрэлийн гадаргуугийн үлдмэл талбай гэж ялгалаа. Гэхдээ эдгээр ялгасан талбайнууд нь неотектоникийн хөдөлгөөнөөр янз бүрийн түвшинд өргөгдсөн ба суусан байдалтай ажиглагдана.

2.5. Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал

Дундговь аймгийн нутгийн хойт хэсэг нь хээрийн хүрэн хөрсний, өмнөд хэсэг нь цөлөрхөг хээрийн говийн бор хөрсний мужид хамрагдана. Аймгийн нутаг нь газрын гадаргын өндөр нам, хотгор гүдгэрийн харилцан адилгүйгээс хөрс үүсгэгч эх чулуулаг нь нэлээд олон янз юм. Нутгийн ихэнх хэсэгт гол төлөв дөрөвдөгч галтын үеийн чулуулгийн хурдсууд зонхилон тархана. Аймгийн нутгийн хөрсөн бүрхэвч уулын хөрс, /уулын хүрэн, цайвар хүрэн, бор/, уулсын хоорондох хөндийн нугын хужир, мараалаг карбонатлаг, алювийн нугын, уулсын хооронд хөндийн хүрэн ба цайвар хүрэн, цөлөрхөг хээрийн бор, элсэн хужаастай болон хад цохио гэсэн хэв шинжид хуваагдаж байна.

Аймгийн хөрсний хэв шижийн зургийг үндэслэн тэдгээрийн эзлэх талбайн хэмжээг тодорхойлж дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 4. Хөрсний хэв шинж

№	Хөрсний нэр	Код	Талбай,га	Эзлэх хувь
1	Уулын хүрэн хөрс	1502	987941.6	13.2
2	Уулын цайвар хүрэн хөрс	1503	625884.4	8.4
3	Уулын цөлөрхөг хөрс	1601	477406.4	6.4
4	Гүйцэт бус хөгжилтэй хүрэн хөрс	2106	71531.7	1.0
5	Хар хүрэн хөрс	2202	8654.7	0.1
6	Жинхэнэ хүрэн хөрс	2203	1673163.4	22.4
7	Цайвар хүрэн хөрс	2204	1538165.4	22.4
8	Цөлөрхөг хээрийн бор хөрс	2301	1640420.1	22.0
9	Хээржүү цөлийн цайвар бор хөрс	2302	4913.8	0.1
10	Цөлөрхөг хээрийн нугат, далд глейрхэг бор хөрс	2303	6219.5	0.1
11	Шал, Шалархуу хөрс	2308	14053.4	0.2
12	Нугын ердийн хөрс	3101	1941.9	0.0
13	Нугын хээржсэн хөрс	3104	248.7	0.0
14	Нугат намгийн цэвдэгт хөрс	3108	2341.3	0.0
15	Аллювийн нуга-намгийн хөрс	3201	864.8	0.0
16	Аллювийн нугын хөрс	3206	2220.7	0.0
17	Аллювийн ширэгт хөрс	3212	4635.4	0.1
18	Нугын хужир хөрс	3302	408412.3	5.5
Нийт талбай			7469019.6	100.0

Хүснэгтээс үзэхэд тус аймгийн нутагт нийт 18 хэв шинжийн хөрс тархаж байгаа тэдгээрийн дотор уулын хүрэн хөрс, уулын цайвар хүрэн хөрс, уулын цөлөрхөг хөрс, жинхэнэ хүрэн хөрс, цайвар хүрэн хөрс, цөлөрхөг хээрийн бор хөрс хамгийн их тархсан байна. Жинхэнэ хүрэн хөрс болон цайвар хүрэн хөрс цөлөрхөг хээрийн бор хөрс нь хамгийн их тархалттай буюу нийт нутгийн 66.8%-д тархсан байна.




График 1. Дундговь аймгийн хөрсний хэв шинж

2.6. Ургамлын нөмрөгийн төлөв байдал

Дундговь аймгийн нутаг дэвсгэр нь ургамал-газарзүйн мужлалаар Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог болон Дундад Халхын хээрийн тойргийн заагт (Өлзийхутаг, 1985), ургамалжлын бүс, бүслүүрийн хувьд хуурай хээр ба цөлийн хээрийн шилжилтийн бүс болох цөлжүү хээрийн дэд бүсэд (Түвшинтогтох, 2014) оршино.

Дундговь аймгийн ургамлын зүйлийн бүрдэл:

Монгол орны ургамал-газарзүйн Дундад Халх, Дорноговийн тойргуудын хээрийн бүсийн тодорхой газар нутгаар буюу Дундговь аймагт судалгаа явуулсан болон урьд жилүүдийн хийсэн судалгаа ургамлын цуглуулга, бичиглэлийг харьцуулан боловсруулж 39 овогт хамаарах 123 төрлийн 202 зүйл ургамал бүртгэв. Энэ нь ургамлын судалгааг ургамал ургалтын үеэс хожуу хийсэнтэй холбоотой байж болох юм. Эдгээр бүртгэсэн зүйл ургамлын дотор нэн ховор 6 зүйл, ховор 10 зүйл, эндемик 3 зүйл, субэндемик ургамал 13 зүйл, ашиглалтанд өртөмтгий ашигт ургамал 27 зүйл ургамал байв.

Хүснэгт 5. Ургамлын төрөл зүйл

№	Ургамлын латин нэр	Монгол нэр	№	Ургамлын латин нэр	Монгол нэр
1	<i>Corispermum mongolicum</i>	Монгол Хамхуул	19	<i>Asterothamnus centrali-asiaticus</i>	Төв азийн лавай
2	<i>Artemisia</i>	Монгол Шарилж	20	<i>Artemisia frigida</i>	Агь
3	<i>Arenaria capillaris</i>	Хялгасан дэвхэргэн цагаан	21	<i>Aristida heymanii</i>	Бөөдий
4	<i>Artemisia frigida</i>	Хүйтсэг шарилж	22	<i>Arnebia</i>	Бэрээмэг
5	<i>Achnatherum splendens</i>	Гялгар дэрс	23	<i>Inula salsoloides</i>	Марцны зоосон цэцэг
6	<i>Iris tenuifolia</i>	Нарийн цахилдаг	24	<i>Heteropappus altaicus</i>	Алтай согсоот
7	<i>Stelleria dichotoma</i>	Ацан ажигана	25	<i>Gypsophila desertorum</i>	Цөлийн тайр
8	<i>Iris Bungei Maxim</i>	Бунгийн цахилдаг	26	<i>Brachanthemum gobicum</i>	Говийн тост

9	<i>Haplophyllum dauricum</i>	Дагуур хүж өвс	27	<i>Lespedeza dahurica</i>	Дагуур хошоон бут
10	<i>Panzerina lanata</i>	Үсхий нохойн хэл	28	<i>Lepidium cordatum</i>	Зүрхэн цангуу
11	<i>Heteropappus hispidus</i>	Арзгар согсоот	29	<i>Kalidium gracile</i>	Шар бударгана
12	<i>Artemisia scoparia</i>	Ямаан шарилж	30	<i>Tradus mongolorum</i>	Монгол ямаалз
13	<i>Prunus amygdalus</i>	Бүйлс	31	<i>Scorzonera divaricate</i>	Дэрэвгэр хависгана
14	<i>Achnatherum splendens</i>	Дэрс	32	<i>Agrophyllum pungens</i>	Шивүүрт цульхир
15	<i>Cleistogenes caespitosa</i>	Хазаар	33	<i>Aristida Heymanii</i>	Гейманы бөөдий
16	<i>Stipa</i>	Хялгана	34	<i>Stipa gobica</i>	Говийн хялгана
17	<i>Allium polyrhizum</i>	Таана	35	<i>Allium mongolicum</i>	Хөмөл
18	<i>Mongolian chives</i>	Хүмүүл			

2.7. Амьтны аймаг

Монгол оронд 141 зүйл хөхтөн амьтан, 513 зүйл шувуу, 21 зүйл мөлхөгч, 6 зүйл хоёр нутагтан, 74 зүйл загас, 13 мянга гаруй зүйлийн сээр нуруугүйтэн бүртгэгдээд байна. Монгол орны амьтны аймгийн 2018 оны зүйлийн бүрдлийг 1998, 2016 оныхтой харьцуулж үзвэл зүйлийн тоо нь өссөн байна. Сүүлийн 20 гаруй жилийн судалгааны дүнгээр Монгол орны нэн ховор, ховор амьтан болох мазаалай баавгай багадаа 28, хүрэн байвгай 500, баданга хүдэр 6500, Төв Азийн минж 300, голын халиу 100, суусар булга 3500, цоохор ирвэс 900-1200, тахь 649, халиун буга 10000 орчим, хулан 10000, янгир 11000, аргаль 13000, молцог хандгай 16400, хавтгай тэмээ 800-1200, цаа буга 140-200, хар сүүлт 12000, зэрлэг гахай 35000, Монгол бөхөн 4000 гаруй тоо толгой тус тус байгаа бол цагаан зээр 3 сая орчим байна.

Дундговь аймагт 12 зүйл хөхтөн амьтан, 23 зүйл шувуу, 2 зүйл мөлхөгч, 864 орчим зүйлийн шавьж бүртгэгдээд байна. Нэн ховор амьтнаас аргаль хонь, янгир ямаа, ховор амьтнаас хар сүүлт байна.

Үүнээс цагаан зээр 36336 тоо толгой, хар сүүлт 133 тоо толгой, аргаль хонь 1212 тоо толгой, янгир ямаа 771 тоо толгой, монгол тарвага 206 тоо толгой, саарал чоно 488 тоо толгой, шар үнэг 1152 тоо толгой, хярс 882 тоо толгой, монгол ногтруу 23593 тоо толгой, дагуур ятуу 25188 тоо толгой тархан нутаглаж байна.

Хүснэгт 6. Амьтны аймгийн төрөл зүйл

№	Латин нэр	Монгол нэр	№	Латин нэр	Монгол нэр
1	<i>Scarabaeidae</i>	Илтсэн сахалт цох	20	<i>Phodopus campbelli</i>	Орог зусаг
2	<i>Eremias argus</i>	Монгол гүрвэл	21	<i>Vulpes corsac</i>	Хярс
3	<i>Milvus migrans</i>	Сохор элээ	22	<i>Otocolobus manul</i>	Мануул
4	<i>Buteo hemilasius</i>	Шилийн сар	23	<i>Procapra gutturosa</i>	Цагаан зээр
5	<i>Aquila nipalensis</i>	Тарвалжи бүргэд	24	<i>Eupolyphaga sinensis</i>	Хээрийн жоом
6	<i>Falco cherrug</i>	Идлэг шонхор	25	<i>Orthoptera</i>	Далавчтаны баг
7	<i>Perdix daauurica</i>	Дагуур ятуу	26	<i>Tenebrionidae</i>	Хар цохын овог
8	<i>Urupa eops</i>	Бөвөөлжин өвөөлж	27	<i>Falco naumanni</i>	Зээрд шонхор
9	<i>Melanocorypha mongolica</i>	Монгол болжмор	28	<i>Columba rupestris</i>	Хадны тагтаа
10	<i>Oenanthe oenanthe</i>	Адууч чогчиг	29	<i>Calandrella cheleensis</i>	Дэрсний жиргэмэл
11	<i>Passer montanus</i>	Хээрийн бор болжмор	30	<i>Eremophila alpestris</i>	Шоорон эвэрт болжмор
12	<i>Petronia petronia</i>	Хадны боршуу	31	<i>Colvus corax</i>	Хон хэрээ
13	<i>Pyrghilauda davidiana</i>	Монгол божирог	32	<i>Corvus corone</i>	Хар хэрээ
14	<i>Lepus tolai</i>	Бор туулай	33	<i>Passer domesticus</i>	Оронгийн бор шувуу

15	<i>Ochotona pallasi</i>	Монгол огдой	34	<i>Spermophilus pallidicauda</i>	Бозлог зурам
16	<i>Marmot sibirica</i>	Монгол тарвага	35	<i>Allactaga</i>	Алагдаага
17	<i>Ochotona dauurica</i>	Дагуур огдой	36	<i>phrynocephalus</i>	Цоохор хонин гүрвэл
18	<i>Lasiopodomys brandtii</i>	Үлийн цагаан оготно	37	<i>Eremias multiocellata</i>	Могойн гүрвэл
19	<i>Cricetulus longicaudatus</i>	Сүүлэрхэг шишүүхэй	38	<i>Eremias przewalskii</i>	Говийн гүрвэл

2.8. Гадаргын ус

Төслийн талбай нь Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт хамаарна.

Умард говийн гүвээт-Халхын талын сав газар

Умард говийн гүвээт- Халхын дундад талын сав газрын захиргаа нь Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А-293 дугаар тушаалаар анх үндэслэн байгуулагдсан бөгөөд 2014 оны 01-р сарын 13-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн юм.

Умард говийн усны сав газар нь 8 аймаг, 59 сум, нутгийг хамарсан нийт 180404.2 км² талбай бүхий говь, хээрийн бүсүүдийг хамарсан өргөн уудам нутаг юм. Умард говийн усны сав газарт Дундговь аймгийн 92.7 хувь, Говьсүмбэр аймгийн 70.9 хувь, Дорноговь аймгийн 37.3 хувь, Сүхбаатар аймгийн 31.6 хувь, Төв аймгийн газар нутгийн 25.9 хувь, Өвөрхангай аймгийн 14.0 хувь, Хэнтий аймгийн 6.8 хувь, Өмнөговь аймгийн 3.8 хувь тус тус хамрагдаж байна.

Тус сав газар нь далайн төвшнөөс дээш дунджаар 1267 метр өргөгдсөн, баруунаас зүүн зах хүртэл 858 км урт, хойноос урагш 424 км өргөн, 2700 км хилийн цэсийн урттай нутаг хамаарах ба монгол орны бусад сав газруудаас талбайн хэмжээгээрээ 2 дугаарт ордог.

Монгол орны төв ба дундад халхын тал, өмнөд болон зүүн өмнөд говийн бүсийн хур тунадас багатай нутаг дэвсгэрт хамаарагддаг. Газрын гадаргын хувьд баруун хагас нь уулархаг бөгөөд нутгийн ихэнх хэсэг ухаа гүвээт тал, цав толгод, хотгор нам газар болно.

Тус сав газар нь говийн бүсэд хамаардаг, говь хээр хосолсон эх газрын эрс тэс уур амьсгалтай, зуны улиралд +41 хэм хүртэл халж, өвлийн улиралд -40 хэм хүртэл хүйтэрдэг. Салхины дундаж хурд 4.2-4.6 м/сек, зарим үед 35 м/сек хүртэл ширүүсдэг, салхи ихтэй, өдөр шөнийн агаарын хэмийн ялгаа их нутаг юм.

Сав газар нь далайн түвшнээс дээш дунджаар 1267 метр өргөгдсөн, баруунаас зүүн зах хүртэл 858 км урт, хойноос урагш 424 км өргөн, 2700 км хилийн цэсийн урттай нутаг хамаарах ба монгол орны бусад сав газруудаас талбайн хэмжээгээрээ 2 дугаарт ордог.

Дундговь аймгийн гадаргын ус: Дундговь аймгийн хэмжээнд гадаргын ус буюу булаг, шанд, нуур тойром 2020 оны жилийн эцсийн байдлаар 158 байна. Гадаргын усны нөөц нь 0.12км³ байна. Дундговь аймгийн нутгаар урсах цор ганц гол нь Онги гол юм. нурууны өврөөс эх авч, ойт хээр, хээр, говийн бүсийг дамжин 437 км зам туулан өртөөлсөөр Өмнөговь аймгийн нутаг, Улаан нуурт цутгахдаа Сайхан-Овоо, Дэлгэрхангай сумын нутгаар 54 км замыг туулдаг.

ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

3.1 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Энэ бүлэгт төслөөс байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг нөлөөлөлд өртөх орчноор буюу газрын гадарга, уур амьсгал, агаарын чанар, гадаргын болон гүний ус, хөрсөн бүрхэвч, ургамлын аймаг, амьтны аймаг, түүх соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэнд зэрэг чиглэлүүдээр авч үзэн тодорхойлж, тэдгээр нөлөөллийн эрчим, цар хүрээг үнэлэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тусгасан болно.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг газрын гадарга, уур амьсгал, агаарын чанар, дуу чимээ, усан орчин, хөрс, ургамал үзүүлэх байдлаар нь үнэлж, үр дүнг тодорхойлсон.

Хүснэгт 7. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Нөлөөллийн төрөл	шууд	Шууд бус	Өөрөө эрхицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт										
Гадаргын усны өөрчлөлт										
Агаарын чанарын өөрчлөлт	x				x		x	x		
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x		x			
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x	x		
Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x		x			
Зэрлэг амьтдын орон зай		x			x		x			x
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x			x					x
2. Байгалийн нөөцийн ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг										
Бэлчээр, тэжээлийн байдал		x			x		x			x
Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x			
Эрчим хүчний нөөц										
3. Байгаль орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ										
Урсгал усны хэрэгцээ										
Агаарын бохирдол	x				x		x	x		
Хөрсний эвдрэл, бохирдол	x				x		x		x	
4. Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл,соёлт давхаргад үзүүлэх нөлөөлөл										
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх										
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх										
Тусгай хамгаалалтай ба цогцолбор газарт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										

Нөлөөллийн төрөл	шууд	Шууд бус	Өөрөө эрхицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
5. Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	x				x		x			x
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x	x		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x			x
Ажлын байр нэмэгдэх	x				x		x			x
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x		x			x
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	x				x		x			x
6. Бусад нөлөөлөл										
Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх	x				x		x		x	
Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	x			x			x			x
Хүчтэй салхи, уруйн үер										
Нийт	17	3		1	19		19	5	6	9

Дээрх хүснэгтээс дүгнэхэд байгаль орчинд нөлөөлж болзошгүй шууд, урт хугацааны, буцалтгүй, бага зэргийн нөлөөлөл нилээд хувийг эзэлж байна. Үүнд

- ✓ Агаарын чанарын өөрчлөлт
- ✓ Ургамлын бүтцийн өөрчлөлт
- ✓ Хөрсний элэгдэл эвдрэл
- ✓ Уур амьсгалын өөрчлөлт
- ✓ Агаарын бохирдол
- ✓ Хөрсний элэгдэл, бохирдол
- ✓ Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх
- ✓ Орон нутгийн орлого нэмэгдэх
- ✓ Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
- ✓ Ажлын байр нэмэгдэх
- ✓ Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
- ✓ Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх
- ✓ Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх
- ✓ Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах шавьж үржих зэрэг байна.

Уг төслийн байршил, техник технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн “магадлан жагсаалт” хүснэгтэнд түүний нөлөөллийн үр дагаврыг “муу”, “дунд”, “сайн” гэсэн утгуудын аль тохирохыг “х” гэж бөглөв.

Хүснэгт 8. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах

Байгаль орчны асуудлууд	Нөлөөлөл байхгүй	Үр дагавар		
		Муу (бага)	Дунд	Сайн (их)
1.Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал				
Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал	х			
Түүх соёлын дурсгалт газар, археологи-палентологийн олдворт газрыг эвдэхэд хүрэх	х			
Усан хангамж, газрын доорх усны горимд өөрчлөлт орох	х			
2. Төслийн шийдэл, төлөвлөөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал				
Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, орчны бохирдлын хяналтын сонгосон төхөөрөмж хир зэрэг зохимжтой				х
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн			х	
Уурхайн үйл ажиллагааны явцад гарах тоосжилтыг бууруулах асуудал хир зэрэг тусгагдсан				х
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх	х			
Үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх		х		
3. Барилга байгууламж барих, үйлдвэрийн аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны үед усны нөөц хомсдох байдал		х		
Төсөл хэрэгжих үеийн хөрсний элэгдэл, эвдрэл				х
Үйлдвэрлэлийн осол, аваар, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах нөхцөл			х	
4.Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх			х	
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх			х	
Хөрсний эвдрэл, элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)			х	
Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан эсэх)		х		
5.Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)				
Төслийн техник технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд болон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал				х

Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл

Төсөл хэрэгжих байршлын хувьд хүн амыг нүүлгэн шилжүүлэх, түүх соёлын археологийн олдворт газарт ямар нэгэн нөлөөлөл байхгүй.

Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал, мөн үйл ажиллагаанаас гарах дуу чимээг багасгах талаар дунд зэргийн үр дагавартай байна.

Төслийг хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал

Төслийг хэрэгжүүлэх нийт ажлын явцад байгаль орчинд хөрсний элэгдэл эвдрэл, газар ашиглалтанд хохирол учруулах зэрэг нөлөөлөл хүчтэй байна.

Гол нөлөөлөл, үргэлжилэх хугацаа, эрчим

“Шарангатай” нэртэй хайлуур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн хүрээнд хайлуур жонш олборлох, гар аргаар ангилан ялгах, тээвэрлэх үйл ажиллагаанууд хийгдэнэ. Ийм далд уурхайн байгаль орчны сөрөг нөлөөллийн асуудлыг авч үзэхдээ Леопольдын матрицын аргыг хэрэглэв.

Хүснэгт 9. Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл

№	Экологийн тогтолцоо	Эрэл хайгуул	Хөрс хуулах (хотхоны барилга, байгууламж)	Тэсэлгээ	Ил уурхайн олборлолт	Гар аргаар ангилан ялгах	Овоолго	Ачих тээвэрлэх	Нийт
1	Агаар		2/3	9/9	2/2	8/8	3/3	4/5	28/30
2	Хөрс		2/5	10/10	3/3	3/3	6/6	2/3	26/30
3	Гадаргын ус								
4	Газрын доорх ус								
5	Ургамал		5/5	9/9	3/3	3/3	8/8	2/3	30/31
6	Ан амьтан		1/1	1/1				1/3	3/5
7	Усны амьтан, ургамал								
8	Геологийн тогтоц		1/1	9/9	8/8			1/1	19/19
9	Байгалийн үзэгсгэлэн		1/1	5/5	2/2	1/1	1/1		10/10
10	Бэлчээр		2/2	5/5	3/3	4/4	6/6	1/1	21/21
11	Хүний эрүүл мэнд		5/6	4/5	9/9	8/8	1/2		27/30
Нийт			19/24	52/53	30/30	27/27	25/26	11/16	164/176

Дээрх хүснэгтийн босоо багануудын нийлбэр дүнгээс үзвэл хөрс хуулах, тэсэлгээ хийх, нүх, карьер ухах, овоолго хийх, ачих тээвэрлэх явц нь агаар, хөрс, ургамал, хүний эрүүл мэнд зэрэгт ихээхэн нөлөөлж болзошгүй нь харагдаж байна.

Нөлөөлөлд хамгийн их өртөгч нь агаар, хөрс, ургамал зэрэг юм.

Нөлөөлөлд орох байдлаар ангилбал агаар 28/30, ургамал 30/31, хөрс 26/30, бэлчээр 21/21, хүний эрүүл мэнд 27/30 1-р ангилалд, геологийн тогтоц 19/19, байгалийн үзэгсгэлэн 10/10 2-р ангилалд орж байна. Иймд 1 ба 2-р ангиллын өртөгчдөд нарийвчилсан судалгаа, тооцоо хийх нь зүйтэй.

Хүснэгт 10. Гол сөрөг нөлөөлөл

№	Байгаль орчны хүчин зүйлс	Гол сөрөг нөлөөлөл
1	Газрын гадарга, хөрс	Уурхайн үйл ажиллагаа болон овоолгоор хөрс, ургамал нь бүр мөсөн устаж, дахин сэргээгдэхгүйгээр үхжинэ.
2	Агаар	Хайлуур жоншийг ачих, тээвэрлэх, овоолго үүсгэх зэрэг үйл ажиллагааны үед агаарын чанарт үзүүлэх нөлөө их байна. Энэ үед тоос, тээврийн хэрэгслээс гарах ШТМ-ын утаа агаарт дэгдэж сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.
3	Ургамал	Нийт талбайн ургамлан бүрхэвч устаж үгүй болно. Нөхөн сэргээгдэх байдал хязгаарлагдмал. Овоолго үүсгэх газрын ургамал мөн устаж үгүй болж ургамлын бүрхэвчийн хэмжээ, бэлчээрийн талбай багасна. Ургамлын нөхөн сэргээгдэх боломжийг судалж, хаягдал хаягдаагүй хэсгүүдийг нөхөн сэргээх шаардлагатай.

3.3 Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Хүснэгт 11. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Үзүүлэх	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх
Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	➤ Тухайн жилийн БОМТ-н БОХТ, БОХШХ-т тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлж, тоос болон бусад хийн хэмжилтийг хийж, тухайн орчны агаарын бохирдолтыг хянаж байх. Төслийн бүхий л үйл ажиллагааны явцад тоосжилтыг хянах бууруулах үр ашигтай бөгөөд практик ач холбогдолтой үйл ажиллагааны журмыг боловсруулан мөрдөх, ➤ Тээврийн хэрэгслийн янданд шүүлтүүр тавих, төслийн үйл ажиллагаанд ашиглах машины техникийн оношилгоо, тохиргоо, үйлчилгээг тогтмол хийж, ашиглалтын нөхцөлийг сайжруулах замаар агаарын бохирдлыг багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай ➤ Хатуу хог хаягдлыг тогтмол ачуулж, төслийн талбайд удаан хадгалахгүй байх ➤ Зориулалтын замаас гадуур өөр зам гаргахгүй байх тал дээр анхаарах ➤ Хэт халалт, агаарын бохирдол тоосжилтыг бага байлгахын тулд ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх
Дуу чимээ, чичиргээнээс үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	➤ Авто машины дуут дохиог гэнэтийн ослоос сэргийлэхээс бусад үед өгөхгүй байх, оройны 10 цагаас хойш ямар нэгэн олныг хамарсан дуу чимээ гаргуулахгүй байх ба ажлын бус цагаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг багасгах ➤ Шуугианы түвшнийг зохицуулж хянаж байх, чимээ ихтэй тоног төхөөрөмж ашиглахгүй байх, ➤ Ашиглахгүй үед тоног төхөөрөмжөө заавал унтрааж байх.
Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	➤ Ундны усны хадгалалт цэвэр, эрсдэлгүй байгааг шалгаж баталгаажуулах. ➤ Хатуу/аюултай хог хаягдлын байгаль орчинд ээлтэй болон бусад менежмент хэрэгжүүлэх
Газрын гадаргад үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	➤ Барилга угсралтын үйл ажиллагаа дууссан даруйд ойр орчмыг хуучин төрхөд ойртуулан нөхөн сэргээх шаардлагатай
Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	➤ Хатуу хучилтгүй замаар зорчих үед автомашины хурдыг хязгаарлах, ➤ Салбар хооронд болон шугам сүлжээний засвар үйлчилгээний замын сүлжээг сайжруулах, ➤ Онц шаардлагагүй тохиолдолд эрүүл газар хөндөхгүй байх, ➤ Замын нэгдсэн сүлжээг бий болгох, цаашид онц шаардлагагүйгээр шинээр зам бий болгохгүй байх, ➤ Хөрс бохирдуулагч материалуудын хяналт, зохицуулалтыг сайжруулах,

	➤ Тээврийн хэрэгслээс шатах, тослох материал асгарахаас сэргийлэх. Асгарсан тохиолдолд түргэн шуурхай сэргийлэх арга хэмжээ авах. ➤ Машин механизмыг зориулалтын талбайд байрлуулах, засвар үйлчилгээг мөн зориулалтын талбайд хийх, ➤ Түлш, тосолгооны материал, химийн бодис агуулах сав гэх мэт болзошгүй эх үүсвэрүүдээс асгаралт үүсэхээс сэргийлсэн хамгаалалтын суурь хийх
Ургамлын нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	➤ Тоосжилт нь ургамлын навчны амсрыг бөглөх, улмаар фотосинтезийн явцыг бууруулах, ургамлын ургалтыг доройтуулах сөрөг нөлөөтэй юм. Иймд хатуу хучилтгүй замд автомашины хурдыг хязгаарлах, замын сүлжээг сайжруулах, тоосжилтыг бууруулах усалгааг хийх, ➤ Онц шаардлагагүйгээр газар хөндөхгүй байх, ➤ Замын нэгдсэн сүлжээг нэн даруй бий болгох, цаашид онц шаардлагагүйгээр шинээр зам бий болгохгүй байх, ➤ Хөрс бохирдуулагч материалуудын хяналт зохицуулалтыг сайжруулах, ➤ Засвар үйлчилгээ, барилга угсралт болон цахилгаан дамжуулах шугамын ашиглалтын үед хэрэглэгдэх машин, механизмыг тогтмол үзлэг оношилгоонд хамруулах, ШТМ-ын асгаралт үүсгэж байгаа эсэхэд хяналт тавих, ➤ Машин механизмыг зориулалтын талбайд байрлуулах, засвар үйлчилгээг мөн зориулалтын байранд хийх ➤ Түлш, тосолгооны материал, химийн бодис агуулах сав зэрэг асгаралт үүсгэж болзошгүй эх үүсвэрүүдээс асгаралт үүсгэхээс сэргийлсэн хамгаалалтын суурь хийх
Нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арилгах арга хэмжээ	➤ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, өндөр давтамж (85 дБА-аас дээш) тай дуу шуугиан үүсгэх ажлыг өдрийн цагаар гүйцэтгэх, ➤ Тээврийн хэрэгслүүд зорчих авто замын маршрутыг барилгын ажил эхлэхээс өмнө гаргах, ➤ Ухсан нүхийг тойруулан гэрэл ойлгогчтой тууз татах, тэмдэгжүүлэх, ➤ Тулгууруудыг суурилуулсны дараагаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг чанартай гүйцэтгэх, ➤ Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан хог хаягдлын нэгдсэн цэгт хаях, ➤ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллах, ➤ Барилгын ажлын явцад ойролцоо нутаглаж буй малчидтай нөхөрсгөөр харилцах, иргэдээс төслийн үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлтийг хүлээн авч зохих арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах зэрэг болно.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа Хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах үйл ажиллагааны явцад байгаль орчинд ямар сөрөг нөлөөлөл үзүүлж байгааг тодорхойлсны үндсэн дээр тус төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор хүрээлэн буй орчинд, хүний эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөлөл, түүнээс сэргийлэх арга зам, анхаарвал зохих асуудлын талаар нарийвчлан төлөвлөлөө. Үүнд: Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр заавал авч хэрэгжүүлж байх арга хэмжээ, агаар, хөрс, ус зэрэг болох байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд тавих талаар хяналт шинжилгээний хөтөлбөрт тодорхой тусгаж оруулсан болно.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгах шаардлагатай байдаг.

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Энэ хэсэгт байгаль орчны судалгааны явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зардал зэргийг оруулсан болно.

Хүснэгт 12. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар									
1	Уурхайн үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, ачилт, тээвэрлэлт, овоолгоос үүссэн тоос нь орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болно	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх	2.4 га талбай ашиглалтанд өртөж буй талбай	га			2.905.0	2026 он	БОС-ын 1995 оны 153тоот тушаал
		Тээвэрлэлтийн үед гарах тоос шороог багасгах үүднээс уурхайн дотоод болон гадаад замуудад хайрга чулуу дэвсэх	Уурхайн тоосжилт ихтэй газар	м³	1.700.0	1	1.700.0	2026 он	-
		Уурхайд орж гарах машин, ачилт буулгалтын цаг хугацаа, хоорондын зайг тоосны сарнилтай уялдуулан оновчтой байлгах тооцоог хийж мөрдөж ажиллах	Уурхай	Үйл ажиллагааны зардалаар					Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2025
		Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, хаалга цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг хийж агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийг бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах	Тоног төхөөрөмжийн хэсэг	ш	850.0	Уурхайн бүх техник хэрэгслүүд	850.0	2026 он	
		Уурхайн машинуудын шүүлтүүр тавих	Уурхайн машин техник	ш	17.0	10	170.0	2026 он	Бензинхөдөлгүүр т MNS 5013:2003 Дизель

									хөдөлгүүрт MNS 5014:2003
		Хүнд машин механизмын утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах, үзлэг шалгалтыг хийх засвар үйлчилгээг тогтмол хийх	Уурхайд ашиглаж буй тээврийн хэрэгсэл, техник	Үйл ажиллагааны зардлаар					Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
2	Ажиллагсад болон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх	Уурхайн ажиллагсад тоосноос хамгаалах хошуувч, амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах сургалт явуулах	Нийт ажилчдад	ХАБ-ын зардлаар					MNS(ISO)13688:2000 MNS3306:1991 MNS5620:2006 MNS5623:2006 MNS5388:2004 MNS5389:2004
Усны нөөц, чанар									
3	Гүний усыг ашигласнаар усны нөөц хомсдох, усны	Ахуйн бохир усыг цэвэршүүлэн ногоон байгууламжийн усалгаанд ашиглах,	Уурхайн талбай	-	-	-	500.0	2026 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль,
4	бохирдол, шатах тослох материалыг алдсанаар	Үйлдвэрлэлийн болон ахуйн усны хэрэглээг тооцох хэмнэлттэй зарцуулах техник технологи ашиглах	Гүний худаг	Ширхэг	ҮА-ны зардлаар			2026 он	
5	газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтанд сэргөөр нөлөөлж болзошгүй.	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авч гэрээ байгуулах		Ширхэг	250.0	1 ш	250.0	2026 он	
Хөрсөн бүрхэвч									
6	Ордын ашиглалтын	Шимт хөрсний овоолго хийх, хадгалах	Уурхай	-	-	-	-	2026 он	MNS 5915:2008
7	явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал, тоосжилтоос	Уурхайн орчны замыг стандартын дагуу тавих, тэмдэгжүүлэх, ажил хийх, олон салаа зам гаргахаас сэргийлэх	Үйл ажиллагааны турш				850.0	2026 он	MNS 4597:2014

8	бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд	ШМТ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, хадгалалтад хяналт тавих	ШТМ-ын агуулах	-	-	-	-	2026 он	
9	олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх.	Машин механизмын засвар үйлчилгээ хийх талбайд бетон хучилт хийх	Засварын талбай		Үйл ажиллагааны зардал			2026 он	
10	ШТМ, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас хөрс бохирдуулах	Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч, операторуудад сургалт явуулах	Нийт ажилчид	-	ҮАЗ			2026 он	
11		Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгыг төлөвлөгөөний дагуу цэгцтэй хураах	Хөрсний овоолго		Уулын ажлын төлөвлөгөөгөөр			2026 он	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
12		Автомашины хурдыг боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах	Тээврийн хэрэгслүүд		ҮАЗ			2026 он	
Дуу чимээ									
	Техник хэрэгслийн дуу чимээ, үйл ажиллагаанаас гарах дуу шуугиан хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Олборлолтын ажлыг өдрийн цагаар гүйцэтгэх	Уурхай					Үйл ажиллагааны турш	MNS ISO 226:2003 дуу чимээ – хэвийн норм- түвшний хэмжээ
		Дуу шуугианы хэмжилт (2 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийж, дуу, шуугиан бүхий машин механизмийн ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй ашиглалтыг багасгах	Улиралд нэг удаа дууны түвшин хэмжигч NL04 багажаар хэмжилтийг хийнэ.		ОХШХ-т тусгав.			Улиралд нэг удаа	
Нийт зардал				7225.0 мян.төг					

4.2. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн ТЭЗҮ болон БОННУ-нд тусгаснаар ашиглалтын сүүлийн жилд нөхөн сэргээлт хийгдэхээр төлөвлөсний дагуу 2026 онд нөхөн сэргээлтийн арга хэмжээ тусгагдаагүй.

4.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 13. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Орон нутгаас ирүүлэх саналын дагуу заасан талбайд эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийх	Техникийн нөхөн сэргээлт	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийх	Орон нутгаас заасан талбайд	-	10,487.0	2026 онд	MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд
	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тари	Уурхайн тосгон орчимд мод тарих	Нөхөн сэргээлтийг заасан талбайд хийж актаар орон нутагт хүлээлгэн өгөх	500 ширхэг	-	5000.0	2026 онд	Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
Нийт			15487.0 мян.төг					

4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй.

Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн Хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” хэмээн заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн

сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөн ажиллах нь зүйтэй.

Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь төслийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны яамны тусгай зөвшөөрөлгүйгээр зааж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

Хүснэгт 14. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Дундговь аймгийн Өлзийт сум	Нутгийн иргэдийн уламжлалт амьдралын хэв маяг, тахилга шүтлэгт хүндэтгэлтэй хандах, дэмжлэг үзүүлэх	Үйл ажиллагааны явцад		600.0		Жилд 1 удаа	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

4.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 15. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Уурхайн ажлын явц дахь болзошгүй осол	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	Уурхайн орчинд	1	1.900.0	1.900.0	2026 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай /2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр/
	Галын аюулаас урьдчилан сэргийлэх	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах		1	1.900.0	1.900.0	2026 он	Галын аюулгүй байдлын тухай хууль
		Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх		Үйл ажиллагааны зардал			2026 он	Гамшгаас хамгаалах тухай хууль

	Байгаль орчныг хамгаалах	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах		1	1.900.0	1.900.0	2026 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
	Химийн бодисын эрсдэл, аюулгүй ажиллагааны байдал, химийн бодисын буруу хадгалалт, тээвэрлэлт зэргээс үүсэх эрсдэл	Химийн бодисыг ашиглах, хадгалах, тээвэрлэх үед гарах осол эрсдлийг тооцож мэргэжлийн байгууллагаар осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж чанд мөрдөн ажиллах, ажилчдыг гарын авлага болон хамгаалах хувцас хэрэгслээр хангах, химийн бодисын хаяг шошго, хадгалах сав болон санамж зөвлөгөөг байршуулах, химийн бодисын хаягдлын арга хэмжээ авах, г.м		Үйл ажиллагааны зардал			2026 он	Гамшгаас хамгаалах тухай хууль
НИЙТ ЗАРДАЛ					5700.0 мян.төг			

4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 16. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаа гүй гээс орчин бохирдох	Хаягдал тосыг хуримтлуулах сав байрлуулах	Үйл ажиллагааны турш	ш	500.0	1	500.0	2026онд	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заатлууд
2		Хог хаягдлыг цуглуулах цэгийг хашаажуулах, тэмдэг тэмдэглээ тавих	Үйл ажиллагааны турш	-	Үйл ажиллагааны зардал				
3		Хатуу хог хаягдлыг цуглуулж, нэгдсэн цэгт хүргэж, устгаж байх /орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулах/	Үйл ажиллагааны турш	Сард 1 удаа	Хог хаягдлын гэрээний дагуу				
4		Хаягдал тос масло, аюултай хог хаягдлыг ангилан цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Үйл ажиллагааны турш	Жилд 2 удаа	Гэрээнд заасны дагуу				
5		Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны турш		Үйл ажиллагааны зардал				
6	Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Шингэн хаягдлыг тусгай бодис хэрэглэн задлах	Үйл ажиллагааны турш	-	-	-	300.0		Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
НИЙТ ЗАРДАЛ					800.0 мян.төг				

4.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тухайн төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн байгаа орчны бүрэлдэхүүн хэсэг (агаар, хөрс, усан орчин)-т үзүүлэх сөрөг нөлөөлөл, өөрчлөлтийг үзүүлж байгаа эсэхэд хяналт тавих, бохирдлыг хянах боломж бүрдэнэ.

Хүснэгт 17. Орчны хяналт шинжилгээний хөлөтбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн зардал, төг	Зардал, мян.төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаарын чанар						
1	Хүхэрлэг хий (SO ₂)	Салхины зонхилох чиглэл болон эх үүсвэрүүдийн байршил (уурхайн, дотоод тээврийн зам, гадаад овоолго, уурхайн тосгон г.м), нөлөөллийн түвшин зэрэгт тулгуурлан уурхайн орчим дахь агаар бохирдуулагчийн тархалтыг гаргахад төлөөлөх чадвартай нийт цэгүүдэд	Жилд 1 удаа	1	500.0	MNS 4585:2025 MNS3113:1981 MNS:3384:1982 MNS:4048:1988
2	Азотын давхар исэл (NO ₂)					
3	PM _{2.5} , PM ₁₀					
4	Дуу чимээ					
Хөрс						
5	Хүнд металлын үзүүлэлт /Хар тунгалаг(Pb), кадми (Cd), хром (Cr), цайр (Zn),никель (Ni), мөнгөн ус (Hg), цианид натри, хүнцэл (As)	Засварын газар, хогийн цэг орчимд	Жилд 1 удаа	50.0	100.0	MNS 5850:2019
6	Ялзмаг, урвалын орчин (pH), давсжилт, карбонат (CaCO ₃), хөдөлгөөнт кали (K ₂ O), хөдөлгөөнт фосфор (P ₂ O ₅), Шингээгдсэн сууриуд Ca, Mg Механик бүрэлдэхүүн,	Ил уурхай, овоолго, ажилчдын тосгон, засварын газар, хогийн цэг орчимд	Жилд 1 удаа	35.0	175.0	MNS 3297:2019
Усан орчин						
7	Физик хими, нянгийн бүрэн шинжилгээ, Хүнд металын шинжилгээ, БХХ болон цэвэршүүлсэн бохир усны стандартад заасан үзүүлэлтүүд	Уурхайн ашиглалтын худгууд	Жилд 1 удаа	-	245.0	MNS 090: 20218
8	Химийн бодисын хаягдлын далангаас усны дээж авах	Уурхайн хаягдлын далан	Улиралд 1 удаа	-	380.0	MNS 6561:2015
Амьтны аймаг						
9	Туруутан амьтдын байршил нутаг, тоо толгой, шилжилт хөдөлгөөн; мөлхөгчид, мэрэгчдийн нягтшил зэргийг тогтоох	Төслийн талбай, түүний ойр орчмын нутагт	1	-	250.0	Биологийн хүрээлэнгийн баталсан арга зүй, Ажиглах бүртгэх

10	Шувуудын нүүдлийн үеэр ажиглалт, мониторинг хийх	Төслийн талбай болон түүний орчмын уст цэг, бусад бүх амьдрах орчинд	1	1	250.0	
Ургамал						
	Хяналтын талбай бүрт 30 м-ийн урттай трансектийг давтамжтай тавьж, трансект тус бүрт он сар өдөр, шалгасан хүний нэр, трансектийн бүртгэлийн дугаар, газрын хэвшил, ургамлын төрөл зүйл зэрэг мэдээллүүдийг авна. Мөн ургамлан нөмрөгийн дээд,доод бүрхэц, ургамлын зүйлийн тоо, арви бүрхэц, бүлгэмдэлд эзлэх хувь зэргийг гаргана.	Төслийн байгууламжийн талбай дахь судалгааны цэг, төслийн талбайд ойр орших ургамлын бүлгэмдлийн хяналтын цэгүүдэд	Жилд 1 удаа (6-7 сард)	500.0	500.0	Батлагдсан арга зүйн дагуу
НИЙТ ЗАРДАЛ					2400.0 мян.төг	

4.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 18. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцоолсон төсөв /мян.төг/	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан/ ажилтан	Баримтлах стандарт, арга аргачлал
			2026					
		Улирал	1	2	3	4		
1	Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	ҮАЗ					Удирдлага	Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”
2	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг хийх	500.0					ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай /2008 оны 5 дугаар сарын 22 өдөр/
3	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбар гаргаж, шинэчилж байх	500.0					ХАБЭА	Байгаль орчныг хамгаалах тухай /1995 оны 3 дугаар сарын 30 өдөр/
4	Ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулах	ХАБ-ын зардлаар					ХАБЭА	Эрүүл ахуйн тухай /2016 оны 2 дугаар сарын 4 өдөр/

5	Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөр хамгаалал, хориглосон үйл ажиллагааны таниулах самбар байгуулах	800.0				Байгаль орчны ажилтан	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай /2008 оны 5 дугаар сарын 22 өдөр/
6	Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах	ҮА-ны зардлаар				Байгаль орчны ажилтан	Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам Дугаар 75 /2023 оны 11 дүгээр сарын 10 өдөр/
7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон биелэлтийн тайланг боловсруулахдаа байгаль орчны мэргэжлийн байгууллагын зөвлөгөө авах	500.0				Байгаль орчны ажилтан	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө Дугаар А/618 /2019 оны 10 дугаар сарын 29 өдөр/
8	Тэрбум мод хөтөлбөрийг дэмжих	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан				Байгаль орчны ажилтан болон мод тарих мэргэжлийн байгууллага	Дундговь аймгийн БОГ-с өгсөн саналын дагуу мод тарих газрыг харилцан тохиролцон хэрэгжүүлнэ. Мөн өмнө мод тарьсан газарт арчилгааны зардалд хандивлах замаар явж болно.
НИЙТ ЗАРДАЛ						2300,0 мян.төг	

4.10. Нөлөөллийн бүсийн иргэдэд тайлагнах ажлын төлөвлөгөө

Хүснэгт 19. Нөлөөллийн бүсийн иргэдэд тайлагнах ажлын төлөвлөгөөний зардал

№	БОМТ түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх	Мэдээний агууллага	Хугацааны тов	Хэлэлцүүлэгээр санал авах	Зохион байгуулах газар
1	БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Дундговь аймгийн Өлзийт сумын засаг захиргааны байгууллагад танилцуулж, хэлэлцүүлнэ.	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж сумын засаг захиргаанд хүргүүлнэ.	БОМТ-ний биелэлт	БОМТ-ний хэрэгжилтийн явцад орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон оршин суугчдад танилцуулна.	Сумын засаг захиргааны удирдлага болон байгаль орчны байгууллагын санал, шүүмжийг хүлээн авч шийдвэрлэх	Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг захиргааны байранд
2	БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Дундговь аймгийн Өлзийт сумын нутгийн оршин суугчдад танилцуулж хэлэлцүүлнэ.	Нутгийн оршин суугчдад БОМТ-ний биелэлтийг тайлагнах	БОМТ-ний биелэлт		Оршин суугчдын санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх	

Төслийн 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардлыг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 20. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний
зардлын нэгдсэн дүн

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Гүйцэтгэх хугацаа	Нийт дүн
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	төг	2026 он	7,225,000
2	Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө	төг		-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төг		15,487,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	Төг		-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө			600,000
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	төг		5,700,000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	төг		800,000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	төг		2,400,000
9	Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө			2,300.000
10	Нөлөөллийн бүсийн иргэдэд тайлагнах ажлын зардал			-
НИЙТ ДҮН				34,512,000 төг